



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.1, 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аж үйлдвэрийн яам (хуучнаар), Хөрөнгө оруулалтын газар (хуучнаар)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан, элэгдлээрээ өртгөө нөхсөн, нийт 141,164,110.34 (нэг зуун дөчин нэгэн сая нэг зуун жаран дөрвөн мянга нэг зуун арван төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгийн хавсралтад заасан 4 ширхэг хөрөнгө (автомашин)-ийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэбаярт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 107 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2016 оны 125 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 1, 3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ 
А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ 
Б.ЭРДЭНЭБАЯР

0000656

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн
399 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН БАЛАНСАД
БҮРТГЭХ ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Волксваген, 90-18 УНЗ	2010	ш	1	58,814,466.39	58,814,466.39
2	Ниссан экстрэйл, 18-44 УБӨ	2007	ш	1	22,835,589.90	22,835,589.90
3	Ниссан экстрэйл, 18-42 УБӨ	2007	ш	1	38,014,054.05	38,014,054.05
4	Соната-6, 10-15 УБҮ	2007	ш	1	21,500,000.00	21,500,000.00
	Нийт дүн				141,164,110.34 (нэг зуун дөчин нэгэн сая нэг зуун жаран дөрвөн мянга нэг зуун арван төгрөг гучин дөрвөн мөнгө)	